

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны . дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ (шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Ерөнхий зүйл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хууль тогтоомж

2.1.Хувь хүний орлогын албан татвар /цаашид "албан татвар" гэх/-ын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан хувь хүний орлогод албан татвар ногдуулах харилцааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“аж ахуйн нэгж” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.4-т заасныг;

4.1.2.“биет бус хөрөнгө” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.3-т заасныг;

4.1.3.“бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч” гэж ажлын байр, лангуу бүхий байршилд байрлахгүй худалдаа, үйлчилгээ, зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч хувь хүнийг;

4.1.4.“гадаад улсад олсон орлого” гэж энэ хуулийн 4.1.7, 4.1.8-д зааснаас бусад орлого;

4.1.5.“малчин өрх” гэж малыг байнга маллаж, ашиг шимээр нь үндсэн орлогоо олдог гэр бүлийг;

4.1.6.“мал бүхий этгээд” гэж энэ хуулийн 4.1.5-д зааснаас бусад мал өмчилж байгаа хувь хүнийг;

4.1.7.“Монгол Улсад олсон орлого” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.7-д заасантай адилтгах орлогыг;

4.1.8.“Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.8-д заасантай адилтгах орлогыг;

4.1.9.“үл хөдлөх эд хөрөнгө” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.2-т заасныг;

4.1.10. “тогтмол бус үйл ажиллагаа” гэдэгт тухайн хувь хүний хууль, аливаа хэлцлийн дагуу байнга эрхлэх албан үүрэгтэй нь холбоогүй, орлогын тогтмол эх үүсвэр болдоггүй ажил, үйлчилгээг хамааруулна;

4.1.11.“суутган төлөгч” гэж Татварын ерөнхий хуулийн 5.1.13-т заасныг;

4.1.12.“харилцан хамаарал бүхий этгээд” гэж Татварын ерөнхий хуулийн 36.7-д заасныг;

4.1.13.“үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгж” гэж Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн эзэмшдэг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.22-т заасан гадаадын аж ахуйн нэгжийг;

4.1.14.“эцсийн эзэмшигч” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.23-т заасныг.

5 дугаар зүйл.Албан татвар төлөгч

5.1.Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна.

5.2.Албан татвар төлөгчийг Монгол Улсад байнга оршин суугч болон Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч гэж ангилна.

5.3.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч гэж дор дурдсан нөхцөлийн аль нэгийг хангасан хувь хүнийг хэлнэ:

5.3.1.үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад оршин суусан хувь хүн;

5.3.2.Монгол Улсад байнга амьдардаг орон гэртэй хувь хүн.

5.4.Хэрэв хувь хүн нь энэ хуулийн 5.3.2-т заасны дагуу Монгол Улсад болон бусад улсад байнга амьдардаг орон гэртэй бол түүний хувийн болон эдийн засгийн язгуур эрх ашгийн төв нь Монгол Улсад байгаа тохиолдолд түүнийг Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч гэж үзнэ.

5.5.Энэ хуулийн 5.3-т заасан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийг тодорхойлоход энэ хуулийн 5.3.1, 5.3.2-т заасан дарааллыг баримтална.

5.6.Гадаад улсад томилогдон ажиллаж буй Монгол Улсын төрийн албан хаагч Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч байна.

5.7.Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчид (цаашид “оршин суугч бус албан татвар төлөгч” гэх) Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олсон, энэ хуулийн 5.3, 5.6-д зааснаас бусад хувь хүнийг хамруулна.

5.8.Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийг дараах байдлаар ангилна:

5.8.1.өөрийн төлөөний газраар дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч хувь хүн;

5.8.2.энэ хуулийн 5.8.1-д зааснаас бусад Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч хувь хүн.

5.9.Төлөөний газрыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлно.

5.10.Энэ хуулийн 5.3.1-д заасан хугацааг Монгол Улсын хилээр орсон өдрөөс хуанлийн хоногоор тоолох бөгөөд олон удаа орж гарсан тохиолдолд албан татвар төлөгчийн Монгол Улсад байсан хоногийн нийлбэрээр тодорхойлно.

5.11.Энэ хуулийн 5.10-т заасан нийлбэрийг тодорхойлоход тухайн татварын жил болон түүний өмнөх татварын жилийг хамруулан тооцно.

5.12.Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн салбарт томилогдон ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүд нь Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчид хамаарахгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Албан татвар ногдох орлого

6 дугаар зүйл.Албан татвар ногдох орлого

6.1.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй, түүнчлэн гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно.

6.2.Энэ хуулийн 5.8.1-д заасан хувь хүний өөрийн төлөөний газраараа дамжуулан тухайн татварын жилд зөвхөн төлөөний газрын үйл ажиллагаатай холбогдуулан Монгол Улсад, Монгол Улсаас эх үүсвэртэй болон гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно.

6.3.Энэ хуулийн 5.8.2-д заасан Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдоно.

6.4.Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:

6.4.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

6.4.2.үйл ажиллагааны орлого;

6.4.3.хөрөнгийн орлого;

6.4.4.хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

6.4.5.шууд бус орлого;

6.4.6.бусад орлого.

7 дугаар зүйл.Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого

7.1.Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлого хамаарна:

7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;

7.1.2.ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;

7.1.3.ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг;

7.1.4.төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;

7.1.5.гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;

7.1.6.үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;

7.1.7.бэлнээр олгосон хоол, унааны мөнгө.

8 дугаар зүйл.Үйл ажиллагааны орлого

8.1.Үйл ажиллагааны орлогод хуулийн этгээд байгуулахгүйгээр үйл ажиллагаа явуулж олсон дараах орлогыг хамруулна:

8.1.1.бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил, үйлчилгээний орлого;

8.1.2.хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зэргээр олсон орлого.

8.2.Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна.

8.3.Малчин өрхийн малын ашиг шимээс олдог орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна.

9 дүгээр зүйл.Хөрөнгийн орлого

9.1.Хөрөнгийн орлогод дараах орлого хамаарна:

9.1.1.хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний орлого;

9.1.2.эрхийн шимтгэлийн орлого;

9.1.3.ногдол ашгийн орлого;

9.1.4.хүүгийн орлого.

9.2.Эрхийн шимтгэлийн орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 10.2-т заасныг хамааруулна.

9.3.Ногдол ашгийн орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 10.3-т заасныг хамааруулна.

9.4.Хүүгийн орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 10.4-т заасныг хамааруулна.

10 дугаар зүйл.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого

10.1.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод дараах орлого хамаарна:

10.1.1.үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

10.1.2.биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

10.1.3.хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

10.1.4.хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсан, шилжүүлсний орлого;

10.1.5.эцсийн эзэмшигч хувь хүн өөрийн шууд, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр дамжуулан эзэмшдэг хувьцаа, хувь оролцоогоо бусдад борлуулах, шилжүүлэх замаар газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлж олсон орлого.Шилжүүлэх гэдэгт тухайн эрхийг өөр төрлийн хөрөнгө, үйл ажиллагаагаар харилцан солилцохыг мөн ойлгоно.

10.2.Биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар төлөгч өөрийн эдийн бус хөрөнгө өмчлөх эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна.

11 дүгээр зүйл.Шууд бус орлого

11.1.Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтны албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараах бараа, ажил, үйлчилгээний орлогыг шууд бус орлогод хамруулна:

11.1.1.үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн;

11.1.2.орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, бэлнээр олгосон байрны хөлс, түлшний зардлын төлбөр;

11.1.3.хоолны мөнгө, үзвэр үйлчилгээний олговор;

11.1.4.ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгчийн болон бусад үйлчилгээ үзүүлсний зардлын төлбөр;

11.1.5.ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр;

11.1.6.арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;

11.1.7.ажил олгогчийн төлсөн сайн дурын даатгалын хураамж;

11.1.8.энэ хуулийн 11.1.1–11.1.7-д заасантай адилтгах бусад орлого.

11.2.Ажил үүргээ биелүүлэх нөхцөлийг нь сайжруулах зорилгоор ажил олгогчоос ажилтанд олгож байгаа дараах шууд бус орлогыг албан татвар ногдох орлогод хамааруулахгүй:

11.2.1.тухайн ажлын байранд ажлын цагаар ажиллуулдаг цайны газар, кафе, амралтын өрөөнд бүх ажилтныг адил нөхцөлөөр хоолоор хангасан;

11.2.2.суурин газраас алслагдсан ажлын байранд ажилладаг ажиллагсдыг амрах байр, бусад үйлчилгээгээр хангах, тухайн ажлын байранд ирэх, буцахад нэгдсэн журмаар унаагаар үйлчилсэн;

11.2.3.орон сууц худалдан авах, барихад зориулж ажилтанд арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;

11.2.4.эмчилгээний зардалд зориулж олгосон тусламж, дэмжлэг;

11.2.5.ажил олгогчоос олгож буй албан томилолтын зардал;

11.2.6.хууль тогтоомжийн дагуу ажил олгогчоос олгож байгаа хөдөлмөр хамгааллын болон дүрэмт хувцас, хор саармагжуулах ундааны үнэ, тэдгээртэй адилтгах бусад хангамжийн зардал;

11.2.7.албан томилолтын зардал.

11.3.Энэ хуулийн 11.1-д заасан шууд бус орлогыг ажил олгогчоос уг орлогыг олгохтой холбогдон гарсан зардлын дүнгээр тодорхойлно.

12 дугаар зүйл.Бусад орлого

12.1.Энэ хуулийн 6.4.6-д заасан орлогод дараах орлогыг хамруулна:

12.1.1.шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;

12.1.2.урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого;

12.1.3.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлого;

12.1.4.бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого;

12.1.5.үнэ төлбөргүйгээр бусдаас авсан хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ.

13 дугаар зүйл.Албан татвар ногдох орлогыг тодорхойлох

13.1.Албан татвар ногдох орлогын дүнг тодорхойлохдоо албан татвараас чөлөөлөгдсөн орлогыг хасаж тооцно.

13.2.Албан татвар төлөгч өөрөө буюу түүний өмнөөс өөр этгээд хөрөнгө оруулсан, хуримтлуулсан бол уг хөрөнгийг албан татвар ногдох орлогод оруулан тооцсоныг албан татвар төлөгч нотлох үүрэгтэй бөгөөд хэрэв нотолж чадахгүй бол оруулсан хөрөнгө, хуримтлалын дүнг албан татвар төлөгчийн тухайн жилийн албан татвар ногдох орлогын дүнд оруулан тооцно.

13.3.Харилцан хамаарал бүхий этгээд хооронд зах зээлийн үнээс хямд, эсхүл өндөр үнээр бараа борлуулсан, шилжүүлсэн, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн эсхүл харилцан солилцсон тохиолдолд татварын алба бодит үнэ тодорхойлох журмын дагуу албан татвар ногдох орлогыг тодорхойлно.

13.4.Энэ хуулийн 13.3-т заасан бодит үнийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлно.

13.5.Гадаад валютаар олсон орлого, гарсан зардлыг төгрөгт хөрвүүлэх, бүртгэх, тайлагнахдаа албан татвартай холбогдох аливаа гүйлгээ хийгдсэн өдрийн Монголбанкны албан ханшийг үндэслэнэ.

13.6.Урт хугацаат гэрээ гэдэгт Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.21-д заасныг ойлгох бөгөөд тус гэрээтэй холбогдох орлогод ногдох албан татварыг тодорхойлоход мөн хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

14 дүгээр зүйл.Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

14.1.Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

14.1.1.энэ хуулийн 7.1.1, 7.1.6, 7.1.7-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр;

14.1.2.энэ хуулийн 7.1.2-7.1.5-д заасан орлогын нийт дүнгээр нь.

15 дугаар зүйл.Үйл ажиллагааны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

15.1.Үйл ажиллагааны орлогоос Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.1 дэх хэсэг, 16.2.1-16.2.4, 16.2.6-16.2.8 дахь заалт, 16.5 дахь хэсэг, 17, 18, 19, 20 дугаар зүйлд тус тус заасан нөхцөл, шаардлагыг хангасан зардлыг хасаж албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан хасагдах зардлыг албан татвар төлөгч хувийн хэрэглээндээ зарцуулсан бол албан татвар ногдох орлогоос хасахгүй.

15.3.Албан татвар төлөгч нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнээс өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулсан байвал түүнд ногдох үйл ажиллагааны зардлыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцохгүй.

15.4.Албан татвар төлөгч нь үйл ажиллагаа эрхлэхэд ашиглаж байгаа машин, механизм, тоног төхөөрөмж, барилгыг гэр бүлийнхээ хэрэгцээнд нэгэн зэрэг ашиглаж байгаа бол ашиглалтын зардлыг хувь тэнцүүлэн тооцож албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тусгана.

15.5.Албан татвар төлөгчийн гэр бүлийн гишүүдэд олгосон хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож хасагдах зардалд тооцно.

15.6.Тайлангаар баталгаажсан өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая төгрөг хүртэлх хувь хүн өөрөө хүсэлт гаргаж, харьяалах татварын алба бүртгэж авсан бол түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.

15.7.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчөөр бүртгүүлсэн, энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх албан татвар төлөгч энэ хуулийн 15.6-д заасан хүсэлт гаргахгүй.

15.8.Энэ хуулийн 15.6-д заасан хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх, бүртгэлээс хасахад Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.22-т заасны дагуу батлагдсан журмыг баримтална.

16 дугаар зүйл.Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

16.1.Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

16.1.1.хөрөнгө ашиглуулсны эсхүл түрээслүүлсний нийт орлогоос тухайн хөрөнгийг ашиглуулах эсхүл түрээслүүлэхтэй холбогдон гарсан баримтаар нотлогдох зардлыг хассан зөрүүгээр нь;

16.1.2.эрхийн шимтгэлийн орлогыг нийт дүнгээр;

16.1.3.ногдол ашгийн орлогыг нийт дүнгээр;

16.1.4.хүүгийн орлогыг нийт дүнгээр.

16.2.Албан татвар төлөгчийн хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж татан буугдсан бол тухайн аж ахуйн нэгжийн үлдсэн хөрөнгийг худалдаж олсон орлогоос албан

татвар төлөгчийн хүртсэн хувийг тодорхойлохдоо анх хувь нийлүүлсэн хэмжээгээр хувь тэнцүүлэн хувааж, хувь нийлүүлэхдээ гаргасан зардлыг хасаж тооцно.

17 дугаар зүйл.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

17.1.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

17.1.1.энэ хуулийн 10.1.1-д заасан үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлснээс олсон орлогыг дүнгээр нь;

17.1.2.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан хөрөнгө борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд уг хөрөнгийн шилжүүлсэн орлогоос хөрөнгийн үлдэгдэл өртгийг хассан дүнгээр;

17.1.3.энэ хуулийн 10.1.4-т заасан хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсан, шилжүүлсний орлогоос уг хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдох зардлыг хассан дүнгээр;

17.1.4.хамтран эзэмшиж байсан хувьцаа, үнэт цаас борлуулсан, шилжүүлсэн бол энэ хуулийн 17.1.3-т заасны дагуу хассан зөрүүг тодорхойлсны дараа тухайн албан татвар төлөгчид ногдох хэсгийн үнийн дүнгээр тодорхойлно.

17.1.5.энэ хуулийн 10.1.5-д заасан орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлоход уг эрх борлуулсан, шилжүүлсэн үнийн дүн болон тус эрхийг олж авахтай холбогдон гарсан баримтаар нотлогдох зардлын зөрүүгээр.

17.2.Энэ хуулийн 17.1.5-д заасан эрх борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлоход Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.15, 21.16-д заасан зарчмыг баримтлан, мөн хуулийн 21.17-д заасны дагуу батлагдсан аргачлалыг мөрдлөг болгоно.

17.3.Энэ хуулийн 10.1.5-д заасан эцсийн эзэмшигч нь Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч бол уг албан татвар төлөгчийн хувьцаа борлуулсны орлогод энэ хуульд заасны дагуу албан татвар ногдуулах бөгөөд 17.1.5, 17.2-т заасныг мөрдөхгүй.

18 дугаар зүйл.Шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

18.1.Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо эдгээр орлогын нийт дүнгээр тооцно.

19 дүгээр зүйл.Бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

19.1.Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

19.1.1.шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр;

19.1.2.урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр;

19.1.3.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр;

19.1.4.үнэ төлбөргүйгээр бусдаас авсан хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээний орлогод албан татвар ногдуулах орлогыг Татварын ерөнхий хуулийн 36.3.2-т заасан шууд бус аргаар тодорхойлсон дүнгээр;

19.1.5.бичил, худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч албан татвар төлөгчийн орлогод түүний эрхлэх үйл ажиллагааны онцлог, төрөл, байршил, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, байгаль орчинд учруулах нөлөөлөл зэргийг харгалзан аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурлаас тогтоосон дүнгээр.

19.2.Бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч албан татвар төлөгч нь тайлант жилд олсон орлогоо өөрийн хүсэлтээр энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан орлогод хамааруулан, албан татвар ногдуулан төлж, тайлагнаж болно.

20 дугаар зүйл.Оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэйгээр олсон орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

20.1.Оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

20.1.1.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого олсон бол уг орлогын нийт дүнгээр;

20.1.2.хүүгийн орлогыг нийт дүнгээр нь;

20.1.3.энэ хуулийн 10.1.5-д заасан эрх борлуулсан, шилжүүлсний орлогод энэ хуулийн 17.1.5-д заасны дагуу тооцсон дүнгээр;

20.1.4.энэ хуулийн 20.1.1-20.1.3-т зааснаас бусад бүх орлогыг нийт дүнгээр.

20.2.Монгол Улсад оршин суугч этгээд болон Монгол Улсад оршин суугч бус этгээд хороонд байгуулсан аж ахуйн үйл ажиллагааны гэрээний дагуу тухайн оршин суугч бус этгээдийг төлөөлж Монгол Улсад хүрэлцэн ирж ажилласан хувь хүнд Монгол Улсад оршин суугч этгээдээс олгосон энэ хуулийн 20.1.1-д заасан орлогыг тодорхойлоход дараах нөхцөлийг бүрдүүлнэ:

20.2.1.энэ хуулийн 20.2-т заасан гэрээнд талууд Монгол Улсад хүрэлцэн ирж ажиллах хувь хүний энэ хуулийн 20.1.1-д заасан орлогыг ангилж тусгасан байх;

20.2.2.тухайн хувь хүний Монгол Улсад хүрэлцэн ирж ажиллах хугацаа нь хуанлийн 30 хоног ба түүнээс дээш байх.

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан нөхцөл нь гэрээнд тодорхой тусгагдаагүй тохиолдолд гэрээний үнийн тооцоололд багтсан тухайн хувь хүний Монгол Улсад хүрэлцэн ирж ажиллахтай холбогдон гарсан зардлын дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

20.4.Энэ хуулийн 5.8.1-д заасан Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн тухайн татварын жилд зөвхөн төлөөний газрын үйл ажиллагаатай холбогдуулан Монгол Улсад, Монгол Улсаас эх үүсвэртэй болон гадаад улсад олсон орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж, албан татварыг төлж,

тайлагнахад Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох болон албан татварыг төлж, тайлагнахтай адил зарчмыг баримтална.

21 дүгээр зүйл. Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийг эзэмшигч хувь хүний албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

21.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.3} дахь хэсэгт заасны дагуу баталсан жагсаалтад багтсан улс, түүний нутагт дэвсгэрт орлого олсон үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийг эзэмшигч хувь хүний энэ хуулийн 9.1.2-9.1.4-д заасан орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

21.2. Гадаадын аж ахуйн нэгжийг энэ хуулийн 4.1.13-т заасан тодорхойлолтод хамруулах, 21.1-д заасны дагуу албан татвар ногдуулах орлогыг тодорхойлоход Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.2-т заасан журмыг баримтална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
Албан татварын хувь, хэмжээ

22 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ

22.1. Энэ хуулийн 14, 18 дугаар зүйл, 20.1.1-д зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.

22.2. Энэ хуулийн дараах зүйл, хэсэг, заалтад дурдсан орлогод дор дурдсан хувь, хэмжээгээр тооцож албан татварыг тусгайлан ногдуулна:

22.2.1. энэ хуулийн 17.1.1-д заасан орлогын дүнд 2 хувиар;

22.2.2. энэ хуулийн 19.1.1, 19.1.2-т заасан орлогын дүнд 5 хувиар;

22.2.3. энэ хуулийн 19.1.3-т заасан орлогын дүнд 40 хувиар;

22.2.4. энэ хуулийн 16 дугаар зүйл, 15.1, 17.1.2, 17.1.3, 17.1.5, 19.1.4, 20.1.2, 20.1.3, 21.1-д зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар.

22.2.5. энэ хуулийн 20.1.4-т заасан орлогын дүнд 15 хувиар;

22.3. Энэ хуулийн 15.6-д заасан орлогод 1 хувиар албан татвар ногдуулна.

22.4. Энэ хуулийн 12.1.4-т заасан орлого олж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал дор дурдсан хязгаарт багтаан тогтооно:

22.4.1. ажлын байр, лангуу бүхий байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж буй хувь хүн 2 000-120 000 төгрөг;

22.4.2. хувиараа зорчигч, эсхүл ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж буй хувь хүн 12 000-480 000 төгрөг.

ТАВДУГААР БҮЛЭГ

Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

23 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх орлого

23.1. Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө:

23.1.1.хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж;

23.1.2.хөдөлмөрийн чадвараа 50 болон түүнээс дээш хувиар алдсаныг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоос тогтоосон магадалгаатай хувь хүний орлого;

23.1.3.гамшгийн үед олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газар, хуулийн этгээд, иргэнээс Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэдэд үзүүлж байгаа тусламж;

23.1.4.малчин өрх, мал бүхий этгээдийн зөвхөн малын тоо толгойд ногдох орлого;

23.1.5.Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын болон Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анз;

23.1.6.Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээдүүд хоорондоо газар ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого;

23.1.7.нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллаас орсон орлого;

23.1.8.энэ хуулийн 5.12-т заасан хувь хүний цалин, нэмэгдэл;

23.1.9.энэ хуулийн 23.1.8-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн гадаад улсад олсон орлого.

23.2.Энэ хуулийн 15.6, 19.1.5-д заасны дагуу албан татвар төлж, тайлагнах хувь хүн энэ зүйлд заасан чөлөөлөлтийг эдлэхгүй.

24 дүгээр зүйл.Албан татварын хөнгөлөлт

24.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ /төгрөгөөр/
0-6 000 000 хүртэл	240 000
6 000 000-12 000 000 хүртэл	222 000
12 000 000-18 000 000 хүртэл	204 000
18 000 000-24 000 000 хүртэл	180 000
24 000 000-30 000 000 хүртэл	162 000
30 000 000-36 000 000 хүртэл	144 000
36 000 000 ба түүнээс дээш	-

24.2.Дор дурдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн буюу тариалсан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлнө:

24.2.1.үр тариа;

24.2.2.төмс, хүнсний ногоо, түүний үр;

24.2.3.жимс, жимсгэнэ, түүний үр, суулгац;

24.2.4.тэжээлийн ургамал;

24.2.5.модны суулгац.

24.3.Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар ипотекийн зээлийн хөрөнгөөр хувьдаа, анх удаа орон сууц худалдан авсан бол албан татвар төлөгчид Монгол Улсын Засгийн газрын тодорхойлсон ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүү хоорондын зөрүүд төлсөн дүнтэй тэнцэх хэмжээний албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ.

24.4.Монгол Улсын иргэн өөрийн татвар ногдсон орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан энэ хуулийн 24.3-т зааснаас бусад зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар зөвхөн хувьдаа, анх удаа орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авсан бол албан татвар төлөгчид 6 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ.

24.5.Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд болон асран хамгаалагчаар тогтоогдсон асрамж, дэмжлэгт байгаа хүүхэд гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын сургуульд оюутан, эсхүл суралцагчаар элсэн суралцаж буй тохиолдолд түүний анхны бакалаврын болон дипломын мэргэжил эзэмших сургалтын хугацаанд тухайн татварын жилд төлсөн, баримтаар нотлогдож буй төлбөртэй тэнцэх орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эдлүүлнэ.

24.6.Монгол Улсын иргэн суралцаж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн орлогоосоо албан татвар төлж, улмаар сургалтын төлбөр төлсөн их, дээд болон мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль, коллежид анхлан суралцагчийг энэ хуулийн 24.5-т заасан хөнгөлөлтөд хамруулна.

24.7.Албан татвар төлөгчийн өөрийн хэрэгцээнд зориулан худалдан авсан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур худалдан авсан баримтаар нотлогдож буй төлбөртэй тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эдлүүлнэ.

24.8.Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулж өгсөн баримтаар нотлогдож буй хандивтай тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг албан татвар төлөгчид эдлүүлнэ.

24.9.Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:

24.9.1.донорын олговор;

24.9.2.даатгалын нөхөн төлбөр;

24.9.3.Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагнал.

24.10.Энэ хуулийн 24.7-д заасан тоног төхөөрөмж, бараа, материалын жагсаалтыг Засгийн газар батална.

24.11.Энэ хуулийн 15.6, 19.1.5-д заасны дагуу албан татвар төлж, тайлагнах хувь хүн энэ зүйлд заасан хөнгөлөлтийг эдлэхгүй.

24.12.Албан татвар төлөгчид энэ хуулийн 24.3, 24.4-т заасан хөнгөлөлтийг давхардуулан эдлүүлэхгүй.

24.13.Тайлант хугацаанд албан татварын хөнгөлөлтийг тухайн орлогод ногдуулан төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй.

24.14.Энэ хуулийн 23.1-д заасан чөлөөлөлт болон энэ зүйлд заасан хөнгөлөлт эдлүүлэх журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

25 дугаар зүйл.Гадаад улсад ногдуулсан албан татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох

25.1.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн гадаад улсад ногдуулсан албан татварыг албан татвар төлөгчийн тухайн татварын жилийн төлбөл зохих албан татвараас хасаж тооцно.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасны дагуу гадаад улсад ногдуулсан албан татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийг баримтална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Албан татвар ногдуулах, төсөвт төлөх, тайлагнах, хасалт хийх, буцаан олгох

26 дугаар зүйл.Албан татвар суутган тооцох, төсөвт төлөх

26.1.Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад дор дурдсан журмыг баримтална:

26.1.1.энэ хуулийн 14, 18, 20.1.1-д заасан орлогын дүнд мөн хуулийн 22.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.2.энэ хуулийн 16.1.2-16.1.4, 17.1.5, 20.1.2, 20.1.3-т заасан орлогын дүнд мөн хуулийн 22.2.4-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.3.энэ хуулийн 17.1.1-д заасан орлогын дүнд 22.2.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.4.энэ хуулийн 19.1.1, 19.1.2-т заасан орлогын дүнд 22.2.2-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.5.энэ хуулийн 19.1.3-т заасан орлогын дүнд 22.2.3-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.6.энэ хуулийн 20.1.4-т заасан орлогын дүнд 22.2.5-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх.

26.2.Энэ хуулийн 17.1.5-д зааснаар тодорхойлсон орлогод албан татвар ногдуулахад тухайн эрхийг Монгол Улсад эзэмшиж буй этгээд нь суутган төлөгчийн үүрэг хүлээнэ.

26.3.Албан татвар төлөгчийн мөнгөн хадгаламжид хүү бодох бүрдээ банк санхүүгийн байгууллага нь суутган төлөгчийн үүрэг хүлээж албан татвар ногдуулан суутгана.

26.4.Суутган төлөгч нь хөдөлмөрийн чадвараа 50 болон түүнээс дээш хувиар алдсан хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 23.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно.

26.5.Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж мэдэгдэнэ.

26.6.Суутган төлөгч энэ хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийн дүнг 12 сард тэнцүү хэмжээгээр хуваан тооцно.

26.7.Суутган төлөгч энэ хуулийн 20.2, 20.3-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдох албан татварыг суутган тооцно.

26.8.Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.3-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ.

27 дугаар зүйл.Албан татварыг өөрөө тодорхойлж, төсөвт төлөх

27.1.Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж, дор дурдсан хугацаанд албан татварыг төсөвт төлнө:

27.1.1.энэ хуулийн 15, 16.1.1, 17.1.2, 17.1.3, 19.1.4-т тодорхойлсон орлогод энэ хуулийн 22.2.4-т заасан хувиар тооцон сар бүр албан татвар ногдуулан, дараа сарын 15-ны өдрийн дотор;

27.1.2.татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 16.1.4-т заасан мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогод энэ хуулийн 22.2.4-т заасан хувиар албан татвар ногдуулж дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

27.1.3.энэ хуулийн 21.1-д зааснаар тодорхойлсон орлогод мөн хуулийн 22.2.4-т заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

27.1.4.Монгол Улсад оршин байнга суугч албан татвар төлөгчийн гадаад улсад олсон энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан орлогод 22.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

27.2.Энэ хуулийн 19.1.5-д заасан татварыг бичил, худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь уг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ олгохдоо хураан авч, тухай бүр төсөвт төвлөрүүлнэ.

27.3.Энэ хуулийн 4.1.3-т заасан зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч нь албан татвар төлснийг нотлох зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг биедээ авч явна, эсхүл тээврийн хэрэгсэлдээ ил байрлуулна.

27.4.Энэ хуулийн 27.2-т заасан зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг авсан албан татвар төлөгчийн албан татвар төлснийг нотлох баримтын загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

28 дугаар зүйл.Албан татвар тайлан хүргүүлэх хугацаа

28.1.Суутган төлөгч нь энэ хуулийн 14, 16.1.2-16.1.4, 17.1.1, 17.1.5, 18, 19.1.1-19.1.3, 20.1.1-20.1.4-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.

28.2.Албан татвар төлөгч энэ хуулийн 15, 16.1.1, 17.1.2, 17.1.3, 19.1.4, 21.1-д заасны дагуу тодорхойлсон орлого, гадаад улсад олсон 16.1.4-т заасны дагуу

тодорхойлсон орлогод ногдуулсан албан татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.

28.3.Бичил, худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь энэ хуулийн 27.2-т заасны дагуу хураан авсан албан татварын тайланг харьяа татварын албанд дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

28.4.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн гадаад улсад олсон энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан орлогод ногдуулсан албан татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ

29 дүгээр зүйл.Албан татварын буцаан олголт

29.1.Албан татвар төлөгч, суутган төлөгчийн энэ хуулийн 28.1, 28.2, 28.4-т заасны дагуу хүргүүлсэн тайлангаар албан татварын илүү, дутуу төлөлтийн тооцооллыг харьяалах татварын алба дараах журмаар нягталж, эцсийн тооцоо хийнэ:

29.1.1.татварын жилд албан татвар төлөгчид буцаан олгох татварын хэмжээ нь энэ хуулийн 24.13-т зааснаар хязгаарлагдана;

29.1.2.албан татвар төлөгч энэ хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг эхэлж эдэлнэ;

29.1.3.энэ хуулийн 24.1-д зааснаас бусад хөнгөлөлтийг албан татвар төлөгч мөн хуулийн 29.1.1-д заасан хязгаарт багтаан өөрөө сонгон эдэлнэ;

29.1.4.албан татвар төлөгч энэ хуульд заасан хөнгөлөлтийг хэсэгчлэн эдлэхгүй;

29.1.5.энэ хуулийн 24.4-т зааснаас бусад хөнгөлөлтийг дараагийн татварын жилд шилжүүлэн эдлүүлэхгүй.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн албан татвар нь төлбөл зохих албан татварын хэмжээнээс бага тохиолдолд харьяалах татварын алба албан татвар төлөгчид мэдэгдэж, эцсийн тооцоог хийнэ.

29.3.Энэ хуулийн 29.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн албан татвар, төлбөл зохих албан татварын хэмжээнээс давсан тохиолдолд илүү гарсан дүнг Татварын ерөнхий хуулийн 44.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

29.4.Энэ хуулийн 29.3-т заасан албан татвар төлөгчийн буцаан авах, илүү төлсөн татварыг дараах журмаар буцаан олгоно:

29.4.1.буцаан олголтыг тухайн татварын албаны харьяалагдах засаг захиргааны нэгжийн төрийн сангийн дансаар дамжуулан албан татвар төлөгчид буцаан олгоно;

29.4.2.харьяа татварын алба энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан тайлан хүргүүлэх хугацаанаас хойш ажлын 20 өдөрт багтаан буцаан олгох татварын хэмжээг хянан тодорхойлж, харьяалах төрийн сангийн нэгжид хүргүүлнэ;

29.4.3.энэ хуулийн 29.4.1-д заасан буцаан олголтыг дараа жилийн 2 дугаар улиралд багтаан олгоно.

29.5.Энэ хуулийн 29.4-т заасан албан татвар төлөгчийн илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

29.6.Буцаан олгох албан татвар нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд тухайн жилд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 20 хувиас хэтрэхгүй байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад

30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

30.1.Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ